



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2026 оны 06 дугаар сарын 02  
№21 (1416)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- |     |   |     |
|-----|---|-----|
| 72. | Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай  | 959 |
| 73. | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай | 963 |
| 74. | Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай                                       | 965 |
| 75. | Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай                                  | 967 |
| 76. | Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай  | 969 |

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- |     |                            |           |     |
|-----|----------------------------|-----------|-----|
| 77. | Хуулийн төсөл буцаах тухай | Дугаар 18 | 970 |
|-----|----------------------------|-----------|-----|



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 05 дугаар  
сарын 01-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 19<sup>1</sup> дүгээр зүйл нэмсүгэй:

#### “19<sup>1</sup> дүгээр зүйл. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын ил тод байдал

19<sup>1</sup>.1. Энэ хуульд заасны дагуу хийгдсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тайланг нэгтгэн хадгалж, олон нийтэд ил тод байдлыг хангахад чиглэсэн үндэсний судалгааны нэгдсэн цахим мэдээллийн сантай байна.

19<sup>1</sup>.2. Үндэсний судалгааны нэгдсэн цахим мэдээллийн санд мэдээлэл цуглуулах, удирдлага, зохион байгуулалт, ил тод, аюулгүй байдлыг хангах үүргийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

19<sup>1</sup>.3. Эрдэм шинжилгээ, судалгаа хөгжүүлэлтийн ажил гүйцэтгэгч нь дараах мэдээллийг хуулиар нууцлахыг хориглосноос бусад тохиолдолд уг ажлыг дууссанаас хойш 90 хоногийн дотор үндэсний судалгааны нэгдсэн цахим мэдээллийн санд хүргүүлж, ил тод, хүртээмжтэй байлгана:

19<sup>1</sup>.3.1. энэ хуулийн 3.1.7, 3.1.8, 3.1.9, 3.1.10, 3.1.11-д заасан эрдэм шинжилгээний ажлын тайлан;

19<sup>1</sup>.3.2. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хийсэн судалгаа хөгжүүлэлтийн ажлын тайлан;

19<sup>1</sup>.3.3. тухайн байгууллагын судлаач, эрдэм шинжилгээний ажилтны эрдэм шинжилгээний бүтээлийг өөрийнх нь зөвшөөрлийг үндэслэн;

19<sup>1</sup>.3.4. хуульд заасан бусад.”



**2 дугаар зүйл.** Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсгийн “Үндэсний хорооны тогтоол, зөвлөмжийг үндэслэн” гэснийг хассугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**С.БЯМБАЦОГТ**





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 05 дугаар  
сарын 01-ний өдөр

Улаанбаатар  
хот

### **ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

#### **1/14 дүгээр зүйлийн 14.9 дэх хэсэг:**

“14.9.Энэ зүйл төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагад хамаарахгүй.”

#### **2/42 дугаар зүйлийн 42.10 дахь хэсэг:**

“42.10.Энэ зүйл төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагад хамаарахгүй.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдөр баталсан Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**С.БЯМБАЦОГТ**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 05 дугаар  
сарын 01-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Шинжлэх ухааны Академийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 5 дахь заалт нэмсүгэй:

“5/Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар Академийн харьяа хүрээлэнгийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийн дагуу зарлагдсан сонгон шалгаруулалтад оролцох.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдөр баталсан Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

С.БЯМБАЦОГТ





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 05 дугаар  
сарын 08-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МЭРГЭЖЛИЙН НЭГДСЭН ХОЛБООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6, 8.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“8.6. Улсын бүртгэлийн байгууллага энэ хуулийн 8.1-д заасан шийдвэр гаргахаас өмнө хүсэлт гаргагч, өрсөлдөөний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон бусад этгээдээс тайлбар авах, нэмэлт баримт бичиг, лавлагаа, мэдээлэл гаргуулах, шинжээч томилон ажиллуулж болно.

8.7. Мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэхтэй холбогдсон журмыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.”

**2 дугаар зүйл.** Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4 дэх хэсгийн “Улсын дээд шүүхэд” гэснийг “улсын бүртгэлийн байгууллагад” гэж, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн” гэснийг “улсын бүртгэлийн байгууллагын” гэж, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.4 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 дэх хэсгийн “Улсын дээд шүүх” гэснийг “Улсын бүртгэлийн байгууллага” гэж, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн “Улсын дээд шүүх” гэснийг “улсын бүртгэлийн байгууллага” гэж, 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн Тамгын газар” гэснийг “Улсын бүртгэлийн байгууллага” гэж, 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн Тамгын газар” гэснийг “улсын бүртгэлийн байгууллага” гэж тус тус өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

С.БЯМБАЦОГТ



Бичлэгний үндсэн үндсэн

Бичлэгний үндсэн үндсэн

2026 он 1416/21 №

Бичлэгний үндсэн үндсэн  
Бичлэгний үндсэн үндсэн

Бичлэгний үндсэн үндсэн  
Бичлэгний үндсэн үндсэн

Бичлэгний үндсэн үндсэн  
Бичлэгний үндсэн үндсэн

Бичлэгний үндсэн үндсэн  
Бичлэгний үндсэн үндсэн

Бичлэгний үндсэн үндсэн  
Бичлэгний үндсэн үндсэн

Бичлэгний үндсэн үндсэн  
Бичлэгний үндсэн үндсэн

Бичлэгний үндсэн үндсэн  
Бичлэгний үндсэн үндсэн

Бичлэгний үндсэн үндсэн  
Бичлэгний үндсэн үндсэн

Бичлэгний үндсэн үндсэн





## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 05 дугаар  
сарын 08-ны өдөр

Дугаар 18

Улаанбаатар  
хот

### Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай нарын 21 гишүүнээс 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг эцэслэн батлах саналыг Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**С.БЯМБАЦОГТ**





**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1

Индекс: 200003

